

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 25 оны 02 сарын 18 өдөр

№ R-2025-03

Улаанбаатар хот

2024 оны жилийн эцсийн ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь хэсэг болон ХасБанк ХК (“Банк”)-ийн Дүрмийн 8.6 (ii) дахь заалтад тус тус үндэслэн, Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлаар дараах шийдвэрийг гаргав:

## ТЭМДЭГЛЭХ нь:

- Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 болон 46.8 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ нь татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор шийдвэрлэх шаардлагатай болохыг;
- Банк нь 2024 оны хагас жилийн аудитлагдсан тайланд үндэслэн эхний хагас жилийн ногдол ашигт нэгж хувьцаанд 18.00 (арван найм) төгрөг хуваарилсан болохыг;
- Банкны гүйцэтгэх удирдлага нь Банкны 2024 оны санхүүгийн жилийн эцсийн ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг (“Жилийн эцсийн ногдол ашиг”) мөнгөн хэлбэрээр доорх дүнгээр хуваарилахыг ТУЗ-д санал болгосон ба хуваарилах ногдол ашгийн хэмжээ нь 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан гарсны дараа бүрэн баталгаажихыг; мөн
- Банкны Дүрмийн 8.6 (ii) дахь заалтын дагуу ногдол ашиг хуваарилах эсэх нь стратегийн асуудал бөгөөд хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэх тул ТУЗ нь 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээр баталгаажсан тохиолдолд дор дурдсан дүнгээр Жилийн эцсийн ногдол ашгийг зарлан хуваарилах шийдвэр гаргуулахаар хувьцаа эзэмшигчдэд санал болгож буйг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

- Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсан тохиолдолд, 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээс шалтгаалан Жилийн эцсийн ногдол ашигт нэгж хувьцаанд 27.00 (хорин долоо) төгрөг зарлан хуваарилахыг дэмжсүгэй.
- Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“ХЭЭХ”)-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг Жилийн эцсийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.

3. Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан өдрөөс хойш 7 хоногийн дотор Жилийн эцсийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлж эхэлсүгэй. Хувьцаа эзэмшигч нь ХасБанкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ